



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/93

Хэрлэн сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжих Хэрлэн сумын Тэмүүжин цогцолбор сургуулийн баруун байрлалд Худалдаа үйлчилгээний төвийн барилгын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Дарга: Ж.Гантулга -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Н.Үнэнбат -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн

Гишүүд: Д.Баттулга -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ж.Даваасүрэн -ТББ-н төлөөлөл

Т.Эрдэнэбаатар -ТББ-н төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Ж.Гантулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА